



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/012/НА-СА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудиторын Албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716	Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Цахим хаяг: namchinsureng@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.24 № 378

танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Х.УУГАНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Бугат сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгч байна. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон 54.9 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, мөн орон нутгийн ерөнхий орлогын авлагын үлдэгдэл гэх 2.0 сая төгрөгийг барагдуулаагүй;
- ЗДТГ-ын өөрийн үйл ажиллагааны орлого болох 1.8 сая түрээсийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн;
- Морин эргүүлийн ажлын хөлснөөс 0.3 сая төгрөгийн ХХОАТ суутгасан ч тайлагнаагүй;
- Тайлант онд 3.9 сая төгрөгийн худалдан борлуулсан өвсийг төсөвт дутуу төвлөрүүлсэн;
- Тайлант онд нийт 14.0 сая төгрөгийн өвс худалдан авах гэрээ байгуулсан боловч тухайн өвсийг гэрээнд заасан хугацаанд нийлээгүй байгаа зөрчилд 1.0 сая төгрөгийн алданги тооцоогүй, одоог хүртэл хүлээн аваагүй;

зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан

632502775

бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайданд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.1, 20.2.4, 20.2.5, 20.2.7, 42.2.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.1.3-д заасан заалтай бүрэн нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаад холбогдох шийдвэрийг хүргүүлсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор санхүүгийн нэгдсэн тайлангаар авлага 15.5 хувь буюу 37.0 сая төгрөгөөр барагдаж, өглөг 3.58 буюу 16.3 хувиар буурсан, батлагдсан төсвөөс зардлыг 272.2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 6 хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2,203.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 1,931.6 сая төгрөгийг зарцуулж 272.2 сая төгрөгийг дутуу зарцуулжээ.

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Булган аймгийн Бугат сум нь түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд хандиваар 675.0, орон нутгийн төсвөөс 218.8 нийт 893.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд

дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	501.2	668.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,345.3	2,798.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,846.5	3,467.5
Нийт өр төлбөрийн дүн	22.0	18.4
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,824.5	3,449.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,846.5	3,467.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	3,067.0	3,045.9
Үйл ажиллагааны зардлын дүн	1,874.6	2,033.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,192.4	1,012.3
Үйл ажиллагааны бус үр дүн	(223.5)	(398.1)
Үйл ажиллагааны нийт үр дүн	968.9	614.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/		
Дархин илэрхийлсэн үлдэгдэл	1,855.7	2,834.9
Тайлант оны үр дүн	968.8	614.2
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2,824.5	3,449.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,079.5	2,323.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,765.4	1,711.4
Үйл ажиллагааны мөнгөн ЦМГ	314.1	612.5
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	-	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	238.3	423.9
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(238.3)	(423.9)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	(50.6)	(0.6)
Нийт ЦМГ	25.2	188.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25.2	188.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,931.7
Урсгал зардал		1,530.8
Хөрөнгийн зардал		400.3
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл		0.6
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,931.7
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,926.8
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		74.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		109.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		179.3

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нь бүрэн эрхийнхээ хугацаанд Нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлж “Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг чанд баримтлан, үйл ажиллагаандаа Ардчилсан-Шударга ёсыг удирдлага болгон орон нутагт тулгамдаж буй нийгэм, эдийн засгийн аливаа асуудлыг нийгмийн хэрэгцээ, иргэдийнхээ эрхийг дээдлэн хүндэлж, ил тод байдлыг ханган ажиллах эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэх эрүүл мэндийн чанарын хүртээмж сайжруулна;
- Биеийн тамираар хичээллэх орчин бүрдүүлэх зорилгоор биеийн тамирын тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжлийн холбоодтой хамтрах;
- Нийгмийн хамгааллын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны болон, хүүхэд хамгааллыг сайжруулж гэр бүл хамгааллын төв байгуулах жендерийн тэгш байдлыг хангах;
- Хүүхэд бүрийг СӨБ, ЕБС-ийн үйлчилгээнд хамруулах Монгол сэтгэлгээг төлөвшүүлэх;
- Төв суурингийн ногоон байгууламжийн төлөвлөлтийг боловсронгуй болгож ногоон сум болгон хөгжүүлнэ;
- Мал сүргийн бүтцийг зохистой болгож үүлдэртэй байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх;
- Нийтийн хэв журмыг сахиулж аюулгүй байдлыг хангаж иргэнд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэх;
- Нийт суурьшлын бүсийг хаягжуулж дэд бүтцийг хөгжүүлж иргэдийг амьдрах таатай нөхцөлөөр хангах;
- Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийг бууруулах менежментийн тогтолцоог бүрдүүлнэ;
- Санхүүгийн ил тод байдлын дагуу үр ашигтай зарцуулалт, баримт бичгийн зөрчилгүй болно;
- Авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, ёс зүйг өндөржүүлж, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж төрийн албаны сахилга батыг сайжруулах;

Тав.Аудитын илрүүлэлт

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 84.3 сая төгрөгийн зөрчилд¹ 7.2 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 20.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 57.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 1,329.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 20.9 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоож, 81.7 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 23.76 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн байна.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

Илрүүлэлт:

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон 54,951.4 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, мөн орон нутгийн ерөнхий орлогын авлагын

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үлдэгдэл гэх 2,082.0 мянган төгрөгийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасан заалттай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ЖДҮДС, орон нутгийн ерөнхий орлогын авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зургаа. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ												
ИТХ												
ХХС	2		1		1		1		1		1	
ОНХС	1		1						1		1	
Дүн	3	0	2	0			1	0	1		1	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	6	84.2	4	7.2	1	20.0	1	57.0				
ЗДТГ	8	67.6	5	13.6	2	51.40	1	2.6				
ИТХ	1	1.43	1	1.43								
ХХС	1	1.16					1	1.16				
ОНХС							2	20.0				
Дүн	16	154.4	10	22.23	3	71.4	1	2.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	3	35.2	2	5.43	1	29.77		-
Нийт дүн	3	35.2	2	5.43	1	29.77		-